



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 16 өдөр

Дугаар A/173

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон хороодын төрийн жинхэнэ албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг сайжруулах, шинээр мөрдөх хууль тогтоомжийг сурталчлах сургалтыг 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсугай.

2. Сургалтын хөтөлбөрийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Сургалтад шаардагдах зардал 270.000 /хоёр зуун далан мянга/ төгрөгийг Засаг даргын Тамгын газрын төсвөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч Г.Золзаяад зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангуулж, сургалтыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Г.Сүхбаатар/-т даалгасугай.


ДАРГА



Д.ТӨМӨРБААТАР

1180201253

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын
газрын даргын 2018 оны ...-р сарын ...-ны
өдрийн А/173-р тушаалын нэгдүгээр хавсралт



**“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/-ИЙН
ЗОХИЦУУЛАЛТ, ТӨРИЙН АЛБАНЫ СОЁЛ, СТАНДАРТ,
ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
АВАХ АРГА ХЭМЖЭЭ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Зорилго: Шинээр мөрдөх Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, төрийн албан хаагчийн ёс зүй, үйлчилгээний соёл, сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Хамрах хүрээ: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон хороодын албан хаагчид

Зохион байгуулагч: Төрийн захиргааны удирдлагын хэлтэс


Хугацаа: 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 08:30 цагт

Хаана: СХД-ийн ЗДТГ-ын Иргэний танхимд

| № | Хугацаа | Сэдэв | Илтгэгч |
|---|-------------|--|--|
| 1 | 08:30-08:40 | Нээлт | |
| 2 | 08:40-10:10 | Төрийн албаны тухай хуулийн шинэчлэл ба Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагын тухай хуулийн төлсийн үзэл баримтлал, анхаарах зарим асуудал | А.Алтанзул /Удирдлагын эрх зүйн тэнхимийн багш, дэд профессор/ |
| 3 | 10:10-10:30 | Цайны завсарлага | |
| 4 | 10:30-12:00 | Нийгмийн ёс суртахуун ба төрийн албан хаагчийн ёс зүй, анхаарах асуудал | Б.Оюунчимэг /доктор, профессор/ |
| 5 | 12:00-12:30 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хорооны үйл ажиллагаа, ёс зүйн зөрчилд ногдуулсан сахилгын шийтгэлд хийсэн дүн шинжилгээ /Судалгааны тайлангийн танилцуулга/ | Б.Өлзийсайхан /Судалгааны багын судлаач/ |
| 6 | 12.30-12.35 | Хаалт | |

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын
газрын даргын 2018 оны ...11...-р сарын ...16...-ны
өдрийн А/173-р тушаалын хоёрдугаар хавсралт



ШААРДАГДАХ ЗАРДАЛ

| д/д | Зардлын нэр | Хэмжих нэгж | Үнийн дүн |
|-------------|----------------------|-------------|----------------|
| 1 | Цэвэр ус, цай | 100*1000 | 100.000 |
| 2 | Бичиг хэргийн зардал | 100*1700 | 170.000 |
| Нийт | | | 270.000 |